

СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

1. Үндэсний бахархал, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.

ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ

2. Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, иргэнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

4. Аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг төрөлжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрд нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, өрсөлдөх чадвартай эдийн засгийг бий болгоно.

ТАВ.ЗАСАГЛАЛ

5. Тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг хэрэгжүүлэх замаар эрсдэлийн удирдлагаар хангаж, Хүний эрхийг дээдэлсэн, авлигаас ангид цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжих үйл явцыг хэрэгжүүлнэ.

ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ

6. Байгалийн үнэ цэнэ, өгөөжийг үнэлэн хамгаалж, байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

7. Орон нутаг дахь батлан хамгаалах тогтолцоо бэхжүүлж, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчин болон мэдээллийн аюулгүй байдлыг ханган, гамшгийн эрсдлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

8. Ногоон хөгжлийн чиг баримжаанд тулгуурлан хот байгуулалтын томоохон инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн, иргэдийн ая тухтай амьдрах тохилог орчныг бүрдүүлнэ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:

ЗДТГ-ын дарга В.Болортуяа

Холбоо барих утас: 88095853

Цахим шуудан: Jargalant1927@gmail.com